

**"ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ДӨРӨВ" ОНӨААТҮГ-ЫН 2025 ОНЫ
"ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"**

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт	Авбал зохих оноо	Оноо[1]	Хуви йн жин[2]	
1	2	3	4	5	6	
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх[4]	1	1	10	
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]	1	1	10	
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0,5	0,5	5
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0,5	0,5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0,5	0,5	5
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0,5	0,5	5
Хэсгийн оноо			4	4	40	
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] (<i>гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо</i>)	1	1	10	
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]	1	1	10	
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]	1	0	0	
Хэсгийн оноо			3	3	20	
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]	1	1	10	
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] (<i>Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын</i>)	1	1	10	
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]	1	1	10	
Хэсгийн оноо			3	3	30	
Үнэлгээний нийт оноо, хувь			10	9	90	

$$\text{Эзлэх хувь} = \frac{\text{ҮХХ} + \text{ЁЗМ} + \text{ЁЗДХ}}{10} * 100\%$$

Тайлбар:

- [1] Байгууллагын өөрийн болон харьяа, салбар байгууллагад өгсөн үнэлгээ.
- [2] Авсан оноог 10-аар үржиж хувийн жинг тооцох ба нийт дүн 100-с хэтрэхгүй байна.
- [3] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 2.1 дэх хэсэг, 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 4.1.3, мөн оны 15 дугаар "Свогалтын агүүлга, сэдэв батлах тухай" тогтоол.
- [4] ЁЗХ-ны 2025 оны 04 дүгээр тогтоолоор баталсан "Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт"-д нийцүүлэн баталсан төлөвлөгөөг хавсарган ирүүлнэ.
- [5] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар "Аргачлал батлах тухай" тогтоол.
- [6] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 2.1 дэх хэсэг, ЁЗХ-ны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 4.1.3, мөн оны 15 дугаар "Свогалтын агүүлга, сэдэв батлах тухай" тогтоол.
- [7] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт.
- [8] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал"-ын 8.3.3, мөн оны 07 дугаар "Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах, шалган шийдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай" тогтоол.
- [9] ЁЗХ-ны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 3.8 дахь хэсэг, 2025 оны 08 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.2.2 дахь заалт.
- [10] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт.
- [11] Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.
- [12] Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт.
- [13] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.2.2 дахь заалт.
- [14] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалт.
- [15] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.4.3, 4.4.4 дэх заалт.

БАТЛАВ:

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА



Д.ГАНБОЛД

“ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ДӨРӨВ” ОНӨААТҮГ-ЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 08 сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт болон тайлагдах хугацаа	Хүрэх үр дүн	Хариуцах гишүүн
1	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах	12-р сарын 31-ний өдрийн дотор	Байгууллагын нийт албан хаагчдад танилцуулагдсан байна	Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн
2	Монгол хүний сэтгэлгээ, үнэт зүйл, шинжлэх ухааны судалгаанд үндэслэн нийгмийн ёс суртахууныг дээшлүүлэхэд чиглэсэн албан болон албан бус сургалтыг зохион байгуулах	12-р сарын 31-ний өдрийн дотор	Албан хаагчдын ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлсэн байна	Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн
3	Байгууллагын албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулах	10-р сарын 31-ний өдрийн дотор	Байгууллагын нийт албан хаагчид хамрагдсан байна	Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн
4	Албан хаагчдын ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол мэдээллийг хүлээн авч, ёс зүйн дэд хорооны зөвлөлийн хурлаар хэлэлцэн дүгнэлт гаргах	Тухай бүрт	Ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг түргэн шуурхай шийдвэрлэж, гомдол гаргагчид хариу өгсөн байна	Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн
5	Ёс зүйн дэд хороодын гишүүдийн хараат бус, бие даасан зарчмаар ажиллах нөхцөл, баталгааг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хангах зохицуулалт хийж, холбогдох арга хэмжээг авах	10-р сарын 31-ний өдрийн дотор	Ёс зүйн дэд хорооны нийт бүрэлдэхүүн хараат бус, бие даасан зарчмаар ажилласан байна	Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн

БОЛОВСРУУЛСАН: ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧИГ



А.БАТЗАЯА

“ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ДӨРӨВ” ОНӨААТҮГ-ЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
“ТАЙЛАНГИЙН МАЯГТ”¹

НЭГ. Товч танилцуулга²

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 28 дугаар тогтоолоор 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдөр “Зорчигч тээвэр дөрөв” ОНӨААТҮГ үүсгэн байгуулагдаж, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/763 дугаар захирамжаар Захирал, Ерөнхий инженер, 7 нэгж, нийт 365 орон тоо батлагдсан.

Тус газар нь Улаанбаатар хотын 13 чиглэлд 95 тээврийн хэрэгсэлтэйгээр нийтийн тээврийн үйлчилгээг иргэдэд үзүүлж байна.

ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт³:

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр (2024-2030)”, Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ” болон Ёс зүйн хорооны 2024 оны 13 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийн хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ыг нийт албан хаагчдад танилцуулан, байгууллагын сайтад байршуулсан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолын хавсралтаар “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр /2024-2030 он/-ийг баталсантай уялдуулан тус хорооноос “Зорчигч тээвэр дөрөв” ОНӨААТҮГ-аас албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын 2025 оны төлөвлөгөө”-г боловсруулж, 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр баталсан бөгөөд уг төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд албан хаагчдийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Албан хаагчийн ёс зүйн хариуцлагын зөрчлийн хуудас”-ийг боловсруулж, төлөвлөгөөний хамт, хэлтсүүдэд хүргүүлсэн. Үүнд:

1. Зөрчлийн хуудсыг хөтлүүлэх ажлыг эхлүүлж, мөрдүүлэх;
2. Удирдлагын түвшинд сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж чадавхижуулах;
3. Хамт олны уур амьсгалыг таатай болгох, соён гэгээрүүлэх хүрээнд Ёс зүйн дэд хорооны гишүүд нэгж дээр ажиллах;

¹ Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

² Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

³ Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

4. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор бодит гарсан зөрчил дээр тулгуурлан кейс боловсруулан контент бэлтгэн албан хаагчдад сурталчлан таниулах;
5. Байгууллагын ёс зүйн зөрчилгүй хамт олныг шалгаруулж, сурталчлах;
6. “Сэтгэл зүйч” ажиллуулах талаар судалж, танилцуулах зэрэг болно.

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

“Зорчигч тээвэр дөрөв” ОНӨААТҮГ-ын захирал Д.Жавхлан нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, болон холбогдох хөтөлбөрүүдэд тусгагдсан ёс зүйн хэм хэмжээг сахиж, үлгэр дуурайлал үзүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хариуцлага хүлээлгэх үйл явцад идэвхтэй оролцох зэрэг цогц ойлголтыг мөрдөн ажиллаж байна. Үүнд: хуулийг мөрдөх, үйлчлүүлэгчдийн үнэлгээг чухалчлах, ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчид хариуцлага тооцоход хяналт тавьж ажилласан.

- Хууль эрх зүйн орчинг сахиж мөрдөх: Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон бусад холбогдох хуулиар тогтоосон хэм хэмжээг чанд биелүүлэх.
- Ёс зүйн үлгэр жишээ үзүүлэх: Өөрийн үйл ажиллагаагаараа бусад төрийн албан хаагчдад үлгэр дуурайлал болж, ёс зүй, сахилга хариуцлагын өндөр соёлыг төлөвшүүлэх.
- Хариуцлага тооцох механизмд оролцох: Ёс зүйн дэд хороотой хамтран ажиллаж, албан хаагчдын ёс зүйн зөрчлийг хянан шалгаж, хариуцлага тооцох үйл явцад хяналт тавих.
- Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх: Албан хаагчдад зориулсан ёс зүйн сургалт, боловсрол олгох ажлыг зохион байгуулж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх.
- Үйлчлүүлэгчийн үнэлгээг ашиглах: Албан хаагчдын үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэлээс гадна үйлчлүүлэгчдийн үнэлгээг чухалчилж, ёс зүйн асуудлыг бодлогодоо тусгах зэрэг ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Байгууллагын цахим сүлжээнд ёс зүйн дэд хорооны тушаал болон журам мэдээллийг тухай бүрд байршуулан, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан ажилласан.

Ёс зүйн дэд хорооны гишүүдийн мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 2025 оны 10 дугаар сард Нийслэлийн засаг даргын тамгын газраас зохион байгуулсан “ТАХ-ын ёс зүйн тухай хууль, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сургалтад бүх гишүүдийг хамруулсан.

Нийтийн тээврийн үйлчилгээг иргэдэд хүргэхдээ албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон бусад холбогдох дүрэм журмыг баримталдаг, удирдлага, хамт олны зэрэг хандлага, харилцаанд анхаардаг хамт олныг шалгаруулсан.

2025 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын Ёс зүйн дэд хороонд өргөдөл гомдол болон бусад хэлбэрээр байгууллагын ажилчдын ёс зүйн хэм хэмжээтэй холбоотой гомдол, зөрчилгүй ажилласан байна.

2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр Ёс зүйн хорооны гишүүд болон Авлигатай тэмцэх газар, “Зорчигч тээвэр дөрөв” ОНӨААТҮГ хамтран “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж байгууллагын албан хаагчдыг хамруулсан.

Сургалтыг Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Г.Баярцэцэг удирдан явуулж нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол болон хуулиар хүлээсэн албан үүрэг хоорондын зөрчлөөс

урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, хянах замаар нийтийн албаны үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх нөхцөлийг баталгаажуулж төрийн албаны ил тод, итгэл даах байдлыг хангах ёстой гэдгийг онцлов.

Тайлант хугацаанд байгууллагын хэмжээнд мөрдөж буй дүрэм журмыг шинээр ажилд орсон 155 ажилтанд танилцуулсан байна.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
2025 онд албан хаагчид ёс зүйн зөрчил гаргалгүй ажилласан.	Хэмнэлтийн хуулийн дагуу төсөв хөрөнгө хангалтгүй байснаар олон төрлийн үйл ажиллагаа болон сургалтуудыг зохион байгуулах боломжгүй байсан.
Санал:	
Саналгүй	

Шалгах хэсэг:

- “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан:

Захирал
/Албан тушаал/

Ёс зүйн дэд хорооны дарга:

/Албан тушаал/

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга:

/Албан тушаал/



/Гарын үсэг/

/Гарын үсэг/

/Гарын үсэг/

Д.Жавхлан
/Гарын үсгийн тайлал/

Д.Ганболд
/Гарын үсгийн тайлал/

А.Батзаяа
/Гарын үсгийн тайлал/

Огноо: 2026 оны 01 сарын 02-ны өдөр